



ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

“ДУЛААН ШАРЫН ГОЛ” ТӨХК-ИЙН 2024 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАНД  
ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

АУДИТЫН КОД: ДАА-2025/4/НА-СТА-ТӨА

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг  
дараах хаягаар авна уу.

**Дархан-Уул аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,  
тэргүүлэх аудитор Ш.Мөнхбаяр**

Утас: 70373089 Цахим хаяг: munkhbayarsh@audit.gov.mn

**Аудитын менежер У.Батсүрэн**

Утас: 70373089 Цахим хаяг: batsurenu@audit.gov.mn

**Ахлах аудитор С.Батцэцэг**

Утас: 70373089 Цахим хаяг: battsetsegs@audit.gov.mn

**Аудитор Д.Ариунзаяа**

Утас: 70378845 Цахим хаяг: suvdmaakh@audit.gov.mn



Дархан-Уул аймаг

2025 он



**ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Бурхантын гудамж-1,14 дүгээр баг, Дархан сум,  
Дархан-Уул аймаг, 45059,  
Утас: 7037-3089, Факс: (976) 7037-3089  
Цахим шуудан: darkhanuul@audit.gov.mn  
Цахим хуудас: www.audit.mn

2025.03.14 № 152

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу “Дулаан шарын гол” ТӨХК-ийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх орлого, мөнгөн гүйлгээ, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг**

Тайлант онд Эрчим хүчний сайдын А/200 дугаар тушаалаар 369,900.0 мянган төгрөгийн санхүүгийн дэмжлэг үзүүлсэн байна. Олон жилийн хуримтлагдсан 189,305.5 мянган төгрөгийн сэлбэгийн өглөгийг барагдуулсан байна.

**Аудитын гол асуудал**

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь

4525020296

харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Тайлант онд Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2024 оны 4 дүгээр тогтоол, Эрчим хүчний сайдын А/20 дугаар тушаал, Эрчим хүчний салбарын 2023-2024 оны хамтын хэлэлцээр, Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 84 дүгээр тогтоолыг үндэслэж цалингийн хэмжээг 1.6 хувиар тус тус нэмэгдүүлжээ.

### **Бусад асуудал**

Удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Компанийн 2024-2025 оны өвөлжилтийн бэлтгэл хангах хүрээнд 24 багц ажил төлөвлөж, гүйцэтгэлийг 100 хувиар тайлагнасан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

### **Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага**

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ш.МӨНХБАЯР



## **АГУУЛГА**

<b>1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ</b> .....	3
<b>2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН</b> .....	5
<b>3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА</b> .....	9
3.1 Компани, түүний үйл ажиллагаа .....	9
3.2 Компанийн гадаад, дотоод орчин .....	10
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал .....	10
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого ба толилуулгад орсон өөрчлөлт .....	10
3.5 Зорилтот түвшний төлөвлөгөө, гүйцэтгэл .....	12
<b>4. АУДИТЫН ТАЙЛАН</b> .....	12
4.1 Ерөнхий зүйл.....	12
4.2 Материаллаг байдал .....	13
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт .....	13
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....	13
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт .....	13
<b>4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт</b> .....	14
4.5.1 Завсрын аудитын талаар.....	14
4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн .....	14
<b>4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал</b> .....	14
<b>5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ</b> .....	14
5.1 Төлбөрийн акт .....	14
5.2 Албан шаардлага.....	15
5.3 Зөвлөмж .....	15
<b>6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ</b> .....	16

### **Товчилсон үгийн жагсаалт**


АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ДЭХ	Дулааны эрчим хүч
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
НӨАТ	Нэмэгдсэн өртгийн албан татвар
СТОУС	Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт
ТӨХК	Төрийн өмчит хувьцаат компани
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ТЗБАХ	Техник зохион байгуулалтын арга хэмжээ

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Балансын зүйл	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ХӨРӨНГӨ</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>
1.1	Эргэлтийн хөрөнгө	0.00	0.00
1.1.01	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	20,815,762.99	11,260,972.55
1.1.02	Дансны авлага	211,985,090.91	52,418,886.24
1.1.03	Татвар, НДШ-ийн авлага	2,202,050.00	
1.1.04	Бусад авлага	5,916,829.37	29,063,085.50
1.1.06	Бараа материал	105,585,537.20	85,400,581.00
1.1.07	Урьдчилж төлсөн зардал/тооцоо	60,972,621.44	58,145,090.88
1.1.11	Эргэлтийн хөрөнгийн дүн	407,477,891.91	236,288,616.17
1.2.01	Үндсэн хөрөнгө	6,029,294,992.40	5,853,960,521.50
1.2.02	Биет бус хөрөнгө	89,356,000.00	96,995,083.31
1.2.03	Биологийн хөрөнгө	3,230,000.00	3,230,000.00
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	6,121,880,992.40	5,954,185,604.81
<b>1.3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>6,529,358,884.31</b>	<b>6,190,474,220.98</b>
2.1.1.01	Дансны өглөг	206,848,636.28	20,480,721.50
2.1.1.03	Татварын өр	721,699,294.30	618,122,223.32
2.1.1.04	НДШ - ийн өглөг	61,292,348.78	669,690.86
2.1.1.08	Урьдчилж орсон орлого	1,915,968.00	9,056,790.30
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн	991,756,247.36	648,329,425.98
2.1.2.04	Бусад урт хугацаат өр төлбөр	349,569.12	0.00
2.1.2.06	Урт хугацаат өр төлбөрийн дүн	349,569.12	0.00
2.2	Өр төлбөрийн нийт дүн	992,105,816.48	648,329,425.98
2.3.01	Өмч: - төрийн	6,525,993,994.35	6,525,993,994.35
2.3.06	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	963,314,968.71	979,293,598.58
2.3.08	Эздийн өмчийн бусад хэсэг	610,705,327.18	610,757,327.18
2.3.09	Хуримтлагдсан ашиг	(2,562,761,222.41)	(2,573,900,125.11)
2.3.09.1	Тайлангийн үеийн ашиг	0.00	(11,009,422.48)
2.3.09.2	Өмнөх үеийн ашиг	(2,562,761,222.41)	(2,562,890,702.63)
2.3.11	Эздийн өмчийн дүн	5,537,253,067.83	5,542,144,795.00
<b>2.4</b>	<b>ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН</b>	<b>6,529,358,884.31</b>	<b>6,190,474,220.98</b>



## 2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

/төгрөгөөр/


Мөрийн дугаар	Үзүүлэлт	Өмнөх оны дүн	Тайлант жилийн дүн
1	Борлуулалтын орлого (цэвэр)	4,196,208,844.52	4,678,996,014.19
2	Борлуулалтын өртөг	3,946,008,901.98	4,473,115,474.43
3	Нийт ашиг (алдагдал)	250,199,942.54	205,880,539.76
4	Хүүний орлого		1,404,321.76
5	Бусад орлого	126,198,827.84	116,124,382.69
6	Ерөнхий ба удирдлагын зардал	163,963,566.04	239,389,579.96
7	Бусад зардал	62,713,831.39	97,301,814.00
8	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	1,420,503.59	2,272,727.27
9	Биет бус хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	3,545,454.55	0.00
10	Олз, гарзын дүн	4,965,958.14	2,272,727.27
11	<b>Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)</b>	<b>154,687,331.09</b>	<b>(11,009,422.48)</b>
12	Орлогын татварын зардал	15,652,102.31	0.00
13	Татварын дараах ашиг (алдагдал)	139,035,228.78	<b>(11,009,422.48)</b>
14	<b>Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)</b>	<b>139,035,228.78</b>	<b>(11,009,422.48)</b>
15	Орлогын нийт дүн	-	-
16	Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)	-	-



2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

/Төгрөгөөр/

№	Үзүүлэлт	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
1	2022 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	6,525,993,994.35	946,898,835.21	600,705,327.18	(2,714,249,431.69)	5,359,348,725.05
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-	-	-	-	-
3	Залруулсан үлдэгдэл	6,525,993,994.35	946,898,835.21	600,705,327.18	(2,714,249,431.69)	5,359,348,725.05
4	Бусад дэлгэрэнгүй орлого	-	-	-	-	-
5	Тайлант үеийн цэвэр ашиг ( алдагдал )	-	-	-	139,035,228.78	139,035,228.78
6	Өмчид гарсан өөрчлөлт	-	-	10,000,000.00	-	10,000,000.00
7	Зарласан ногдол ашиг	-	-	-	-	-
8	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	-	16,416,133.50	-	12,452,980.50	28,869,114.00
9	2023 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	6,525,993,994.35	963,314,968.71	610,705,327.18	(2,562,761,222.41)	5,537,253,067.83
10	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-	-	-	-	-
11	Залруулсан үлдэгдэл	-	-	-	-	-
12	Бусад дэлгэрэнгүй орлого	-	-	-	-	-
13	Тайлант үеийн цэвэр ашиг ( алдагдал )	-	-	-	(11,009,422.48)	(11,009,422.48)
14	Өмчид гарсан өөрчлөлт	-	-	52,000.00	-	52,000.00
15	Зарласан ногдол ашиг	-	-	-	-	-
16	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	-	15,978,629.87	-	(129,480.22)	(15,849,149.65)
17	2024 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	6,525,993,994.35	979,293,598.58	610,757,327.18	(2,573,900,125.11)	5,542,144,795.00



ХТ05430 0922899

## 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	Өмнөх оны дүн	Тайлант жилийн дүн
<b>1</b>	<b>Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>		
<b>1.1</b>	<b>Мөнгөн орлогын дүн (+)</b>	<b>3,110,048,140.01</b>	<b>3,838,282,635.76</b>
1.1.1	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	2,061,941,639.33	2,370,052,142.08
1.1.5	Татаас, санхүүжилтийн орлого	970,000,000.00	1,369,936,500
1.1.6	Бусад мөнгөн орлого	78,106,500.68	98,293,993.68
<b>1.2</b>	<b>Мөнгөн зарлагын дүн (-)</b>	<b>3,007,766,487.15</b>	<b>3,709,609,020.68</b>
1.2.1	Ажиллагчдад төлсөн	1,235,406,019.15	1,595,920,428.92
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	763,050,000.00	541,198,130.05
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	446,843,708.23	731,852,594.08
1.2.4	Ашиглалтын зардалд төлсөн	13,259,222.03	12,404,470.34
1.2.5	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	81,429,169.00	71,758,245.00
1.2.7	Татварын байгууллагад төлсөн	301,862,267.51	556,332,806.63
1.2.8	Даатгалын төлбөрт төлсөн	824,670.00	717,840.00
1.2.9	Бусад мөнгөн зарлага	165,091,431.23	199,424,505.66
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	102,281,652.86	128,673,615.08
<b>2</b>	<b>Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>	-	-
<b>2.1</b>	<b>Мөнгөн орлогын дүн (+)</b>		<b>1,404,321.76</b>
2.1.6	Хүлээн авсан хүүний орлого		1,404,321.76
<b>2.2</b>	<b>Мөнгөн зарлагын дүн (-)</b>	<b>85,144,462.74</b>	<b>139,632,727.28</b>
2.2.1	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	85,144,462.74	139,632,727.28
<b>2.3</b>	<b>Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>(85,144,462.74)</b>	<b>(138,228,405.52)</b>
4	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	17,137,190.12	(9,554,790.44)
<b>5</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	<b>3,678,572.87</b>	<b>20,815,762.99</b>
<b>6</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>20,815,762.99</b>	<b>11,260,972.55</b>



## 2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/

№	Техник, эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүд		Хэмжих нэгж	2024 он		Зөрүү	Хувь
				Төлөвлөгөө	Гүйцэтгэл		
1	Боловсруулсан	ДЭХ	Гкал	39,795.2	45,377.8	5,582.6	114.0
	Дотоод хэрэгцээний дулаан эрчим хүч	хувиар	хувь	8.1	7.1	0.0	87.7
		биетээр	гкал	3,220.0	3,220.0	-	100.0
	Эрчим хүч түгээлт	ДЭХ	гкал	36,575.2	42,157.8	5,582.6	115.3
	Олборлох ус		м3	308,918.9	254,728.0	(54,190.9)	82.5
	Борлуулах ус		м3	200,460.0	229,248.5	28,788.5	114.4
	Татан зайлуулах бохир ус		м3	273,215.0	195,614.0	(41,601.0)	82.5
<b>Нийт орлого</b>			<b>мян.төг</b>	<b>4,450,787.9</b>	<b>4,798,797.4</b>	<b>348,009.5</b>	<b>107.8</b>
2	Үүнээс:	Үндсэн үйл ажиллагааны орлого	мян.төг	3,426,447.2	3,433,599.2	7,152.0	100.2
		Үндсэн бус үйл ажиллагааны орлого	мян.төг	115,249.8	119,801.4	4,551.6	103.9
		Төсвийн санхүүжилт	мян.төг	909,090.9	1,245,396.8	336,305.9	137.0
<b>Нийт зардал</b>			<b>мян.төг</b>	<b>4,815,246.7</b>	<b>4,809,806.8</b>	<b>(5,439.9)</b>	<b>99.9</b>
3	Үүнээс:	Үйл ажиллагааны зардал	мян.төг	4,815,246.7	4,809,806.8	(5,439.9)	99.9
		Үйл ажиллагааны бус зардал	мян.төг	-	-	-	-
		Үндсэн хөрөнгийн элэгдлийн зардал	мян.төг	442,850.2	461,189.5	18,339.3	104.1
4	Татварын өмнөх ашиг(алдагдал)		мян.төг	(364,458.8)	(11,009.4)	353,449.4	3.0
5	<b>Цэвэр ашиг (алдагдал)</b>		<b>мян.төг</b>	<b>(364,458.8)</b>	<b>(11,009.4)</b>	<b>353,449.4</b>	<b>3.0</b>
6	Борлуулалтын орлогын 1 төгрөгт ноогдох зардал		төгрөг	1.41	1.00	(0.4)	71.3
7	Нийт авлага		мян.төг	119,650.0	81,482.0	(38,168.0)	68.1
8	Нийт өглөг		мян.төг	1,052,000.0	684,329.4	(403,670.6)	61.6
9	Нийт ажиллагсдын тоо		хүн	101	96	(5.0)	95.0
10	Нийт цалингийн сан		мян.төг	1,822,112.2	1,788,275.9	(33,836.3)	98.1
11	Жишмэл түлшний хувийн зарцуулалт		кг/гкал	199.6	199.6	0.0	100.0
12	<b>Их засвар, хөрөнгө оруулалт, ТЗБАХ</b>		<b>мян.төг</b>	<b>293,806.6</b>	<b>282,411.5</b>	<b>(11,395.1)</b>	<b>96.1</b>

## 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

### 3.1 Компани, түүний үйл ажиллагаа

“Дулаан шарын гол” ТӨХК нь Дархан-Уул аймгийн Шарын гол сумын хэрэглэгчдийг чанартай бүтээгдэхүүнээр найдвартай ханган, инновацийг

нэвтрүүлж, өртөг зардлыг бууруулах зорилтын хүрээнд дулаан эрчим хүч, цэвэр усаар хангах, бохир усыг татан зайлуулах чиг үүргийг хэрэгжүүлэн ажиллаж байна.

### **3.2 Компанийн гадаад, дотоод орчин**

Тус байгууллага нь Эрчим хүчний тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль, Компанийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль, Төсвийн тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон бусад хууль эрхийн актыг үйл ажиллагаандаа мөрдөж байна.

Компанийн гүйцэтгэх захирал зарлагын гүйлгээнд гарын үсэг зурснаар дотоод хяналтыг хэрэгжүүлж байгаа бол дотоод хяналтын нэгж санхүүгийн баримт материал, гүйцэтгэлийн баримт бичгийг хянадаг байна. Мөн Эрчим хүчний яамны хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газраас компанийн 2024 оны санхүүгийн үйл ажиллагаа, хөрөнгө оруулалт, худалдан авах ажиллагаанд аудит хийж 32 зөвлөмж өгснийг хэрэгжүүлж ажиллажээ.

Иймд төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг үр нөлөөтэй гэж тодорхойлон, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэх шаардлагагүй гэж үзсэн.

### **3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал**

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

“Дулаан шарын гол” ТӨХК-ийн 2024 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус компанийн мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тухайн байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

### **3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого ба толилуулгад орсон өөрчлөлт**

“Дулаан шарын гол” ТӨХК -ийн 2024 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2017 оны 361 дүгээр тушаалаар баталсан аж ахуйн нэгжид мөрдөгдөх “Санхүүгийн тайлан, тодруулгыг бэлтгэх заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 338,884.7 мянган төгрөгөөр буюу 5.4 хувиар буурчээ.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Мөнгөн хөрөнгө	20,815.8	11,261.0	(9,554.8)
Дансны авлага	211,985.1	52,418.9	(159,566.2)
Татвар, НДШ-ийн авлага	2,202.1	-	(2,202.1)
Бусад авлага	5,916.8	29,063.1	23,146.3
Бараа материал	105,585.5	85,401.0	(20,184.5)
Урьдчилж төлсөн зардал тооцоо	60,972.6	58,145.1	(2,827.5)
Үндсэн хөрөнгө	6,029,295.0	5,853,960.5	(175,344.5)
Биет бус хөрөнгө	89,356.0	96,995.1	7,639.1
<b>Нийт хөрөнгийн дүн</b>	<b>6,529,358.9</b>	<b>6,190,474.2</b>	<b>(338,884.7)</b>
Богино хугацаат өр төлбөр	991,756.2	648,329.4	(343,426.8)
Урт хугацаат өр төлбөр	349.6	-	(349.6)
Эздийн өмчийн дүн	5,537,253.1	5,542,144.8	4,891.7
<b>Өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>6,529,358.9</b>	<b>6,190,474.2</b>	<b>(338,884.7)</b>

Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл өмнөх оноос 9,554.8 мянган төгрөгөөр буурсан нь татвар, нийгмийн даатгалын өглөгийг барагдуулсантай холбоотой байна.

Авлага дансны 52,418.9 мянган төгрөгийн үлдэгдлийн 39.4 хувь буюу 20,642.2 мянган төгрөг нь аж ахуйн нэгж, байгууллагаас, 60.6 хувь буюу 31,776.7 мянган төгрөг нь айл өрхөөс авах авлага эзэлж байна.

Бараа материал дансны хувьд тайлант оны худалдан авалтаар 1,131,251.5 мянган төгрөгийн материал орлогод авч, гүйцэтгэх захирлын 2024 оны А/46 дугаар тушаалаар 216.6 мянган төгрөгийн бараа материал акталж, 1,151,436.4 мянган төгрөгийн материал зарцуулснаар 85,401.0 мянган төгрөгийн материалын үлдэгдэл тайлагнасан байна. Үүнд дулааны станцын үйлдвэрлэлийн түүхий эд материал болох нүүрс, давс болон аюулгүйн нөөцийн материал 12.7 хувийг эзэлж байна.

Урьдчилж төлсөн зардлын дансны 35,350.0 мянган төгрөг нь бэлтгэн нийлүүлэгчид төлсөн урьдчилгаа, 22,795.1 мянган төгрөг нь НӨАТ-ын илүү төлөлт байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 175,344.5 мянган төгрөгөөр буурсан нь худалдан авсан 139,632.7 мянган төгрөг, хөрөнгө оруулалт, их засварын капиталжуулалтаар 117,104.9 мянган төгрөг, ТӨБЗГ-ын 259 дугаар тогтоолын дагуу дахин үнэлсэн 36,704.4 мянган төгрөг, нийт 293,442.0 мянган төгрөгийн хөрөнгийг данс бүртгэлд тусгаж, ТӨБЗГ-ын 277 дугаар тогтоолоор 5,716.9 мянган төгрөгийн хөрөнгө акталж, ТӨБЗГ-ын 270 дугаар тогтоолоор 52,045.4 мянган төгрөгийн хуримтлагдсан элэгдэлтэй 2 автомашиныг дуудлага худалдаагаар худалдсан нь хөрөнгийн бууралтад нөлөөлсөн байна.

Богино хугацаат өр төлбөр өмнөх оноос 343,426.8 мянган төгрөгөөр буурсан нь нийгмийн даатгалын шимтгэлийн 60,622.6 мянган төгрөг, татварын 103,577.1 мянган төгрөг, хувь хүмүүст 2,141.4 мянган төгрөг, үйлчилгээний хөлс 800.0 мянган төгрөг, байгууллагад төлөх өглөг 189,305.5 мянган төгрөгийг тус тус барагдуулж, НӨАТ-ийн өглөг 599,101.2 мянган төгрөг, ААНОАТ-ын өглөг 19,021.0 мянган төгрөг,

байгууллагад төлөх өглөг 21,116.7 мянган төгрөгөөр тус тус өссөн нь голлон нөлөөлжээ.

Эздийн өмчийн дүн 5,542,144.8 мянган төгрөг болж 4,891.7 мянган төгрөгөөр өсөхөд тайлант онд 11,009.4 мянган төгрөгийн алдагдалтай ажилласан, 15,849.1 мянган төгрөгийн дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжилттэй холбоотой байна.

### **3.5 Зорилтот түвшний төлөвлөгөө, гүйцэтгэл**

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.3, 20 дугаар зүйлийн 20.1.3-д заасны дагуу “Дулаан шарын гол” ТӨХК нь компанийн үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө, техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний төлөвлөгөөг боловсруулж, зохих байгууллагаар батлуулж, биелэлтийг хангах үүрэгтэй.

Эрчим хүчний сайдын 2024 оны 01 дүгээр сарын 03-ны өдрийн А/20 дугаар тушаалаар компанийн 2024 оны техник, эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг баталсан байна.

Тайлант оны нийт орлогыг 4,450,787.9 мянган төгрөгөөр, нийт зардлыг 4,815,246.7 мянган төгрөгөөр тооцож, үүнээс 293,806.6 мянган төгрөгийг их засвар, хөрөнгө оруулалтын арга хэмжээнд зарцуулахаар төлөвлөжээ. Тайлант онд компанийн 2024 оны техник, эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тодотгол хийгээгүй байна.

Гүйцэтгэлээр 4,798,797.4 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, 4,809,806.8 мянган төгрөгийн зардал гарган, 11,009.4 мянган төгрөгийн алдагдалтай ажилласан байна.

Нийт орлогын төлөвлөгөөг 348,009.5 мянган төгрөгөөр буюу 107.8 хувиар биелүүлсэн байна. Энэ нь Эрчим хүчний сайдын А/200 дугаар тушаалаар 1,369,900.0 мянган төгрөгийн татаас, санхүүгийн дэмжлэг үзүүлснээс шалтгаалсан байна.

Нийт зардлын гүйцэтгэл 4,809,806.8 мянган төгрөг болж, төлөвлөснөөс 5,439.9 мянган төгрөг буюу 99.9 хувийн гүйцэтгэлтэй байна. Үүнд батлагдсан орон тооноос 17 орон тоо дутуу ажилласан, нүүрс, шатахуун, бичиг хэрэг, хөдөлмөр хамгааллын хэрэгслийг хэмнэсэн нь гол нөлөө үзүүлжээ.

Их засвар, техник зохион байгуулалтын арга хэмжээ, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний дагуу 6 нэр төрлийн ажилд өөрийн эх үүсвэрээс 282,411.5 мянган төгрөгийн зардлыг санхүүжүүлсэн байна.

Тайлант онд 11,009.4 мянган төгрөгийн алдагдалтай ажиллаж төлөвлөсөн алдагдалаас 353,449.4 мянган төгрөгөөр бага байгаа нь Эрчим хүчний сайдын А/200 дугаар тушаал шийдвэрээр 369,900.0 мянган төгрөгийн санхүүгийн дэмжлэг авч, өвөлжилтийн бэлтгэл ажил, их засвар, өр төлбөрт зарцуулсантай холбоотой байна.

## **4. АУДИТЫН ТАЙЛАН**

---

### **4.1 Ерөнхий зүйл**

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу “Дулаан шарын гол” ТӨХК-ийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланд хийсэн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд компанийн дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Дархан-Уул аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Д.Ариунзаяа гүйцэтгэж, хяналтыг ахлах аудитор С.Батцэцэг, аудитын менежер У.Батсүрэн, газрын дарга, тэргүүлэх аудитор Ш.Мөнхбаяр нар тус тус хэрэгжүүлсэн.

“Дулаан шарын гол” ТӨХК-ийн 2024 оны санхүүгийн тайланг Дархан-Уул аймаг дахь Төрийн аудитын газарт 2025 оны 02 дүгээр сарын 13-ны өдрийн 01/43 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

### **4.2 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт төлөвлөсөн зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2024 оны батлагдсан зардлын 4,815,246.7 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 48,152.4 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### **4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт**

Тайлант онд Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлж ажиллах хүрээнд Төрийн өмчит үйлдвэрийн газар болон төрийн өмчит компанийн үндсэн үйл ажиллагаатай шууд холбоогүй төсөл арга хэмжээ, спорт, баяр ёслол, хурал семинар, ой тэмдэглэх зэрэг нийтийн арга хэмжээг тус тус санхүүжүүлээгүй байна. Хөдөлмөр хамгаалал, бичиг хэрэг, томилолтын зардлыг тус тус хэмнэж ажилласан байна.

### **4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

#### **4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор

www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг харилцах дансны хуулга, тушаал шийдвэр, худалдан авах ажиллагаатай тулган шалгахад худалдан авах ажиллагааны 313,765.0 мянган төгрөгийн 4, төсөв, хөрөнгө зарцуулах 17,270.0 мянган төгрөгийн 9, цалингийн зардлаас бусад 5.0 сая төгрөгөөс дээш орлогын 3,102,155.4 мянган төгрөгийн 79, зарлагын 1,135,031.1 мянган төгрөгийн 57 мэдээллийг шилэн дансны цахим хуудсанд тус тус хугацаанд нь бүрэн байршуулсан байна.

#### 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

##### 4.5.1 Завсрын аудитын талаар

Завсрын аудит хийгдээгүй болно.

##### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар нийт 22,349.9 мянган төгрөгийн зөрчил илрүүлснээс 442.8 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт, 4,416.1 мянган төгрөгийн 1 албан шаардлага хүргүүлж, 17,491.0 мянган төгрөгийн 1 зөвлөмж өгснийг бүрэн хэрэгжүүлж ажилласан байна.

Хүснэгт 2. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитаар өгсөн		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Төлбөрийн акт	1	442.8	1	442.8	100.0
Албан шаардлага	1	4,416.1	1	4,416.1	100.0
Зөвлөмж	1	17,491.0	1	17,491.0	100.0
<b>Нийт дүн</b>	<b>3</b>	<b>22,349.9</b>	<b>3</b>	<b>22,349.9</b>	<b>100.0</b>

#### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

1. Дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй.

### 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 791,510.14 мянган төгрөгийн зөрчил<sup>1</sup>-д орон нутгийн төсөвт буцаан төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоов.

#### 5.1 Төлбөрийн акт

- Аудитаар сахилгын шийтгэлтэй 2 албан хаагчдад 791,510.14 мянган төгрөгийн удаан жилийн нэмэгдэл хөлс олгосон байна. Энэ нь Компанийн гүйцэтгэх захирлын 2011 оны 28 дугаар тушаалаар баталсан "Компанид тогтвор суурьшилтай ажиллаж байгаа

<sup>1</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

*ажилтнуудын ажилласан жилийг үндэслэн удаан жил ажилласны нэмэгдэл олгох журам"-ын 3.А-д "Хөдөлмөрийн сахилгын арга хэмжээ авагдсан хугацаанд удаан жилийн нэмэгдэл олгохгүй" гэж заасантай нийцэхгүй байгаа тул төлбөрийн акт тогтоож аудитын явцад барагдуулсан.*

### **5.3 Зөвлөмж**

Аудитаар зөвлөмж өгөх алдаа, зөрчил илрээгүй болно.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

